



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР
ЗӨВЛӨЛ**

48090 Мандалговь, Дундговь аймаг,

Утас: 7059-2494, Факс: 7059-2896,

2020.07.24 № 42

танай _____-ны № _____-т

Г

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР,
ХЭЛТЭС, АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРТ**

Орон нутгийн сонгууль 10 дугаар сард болохтой холбогдуулан Төрийн жинхэнэ албан хаагч аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нэр дэвшихээр бол 8 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө төрийн албанаас чөлөөлөгдсөн байхаар заасан.

Энэ дагуу Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн “Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах тухай” албан бичгийг хавсралтаар хүргүүлж байна.

Төсвийн шууд захирагчид дээрх албан бичгийг анхаарч үндэслэл сайтай шийдвэр гаргаж, албан хаагчдыг мэдээллээр хангаж ажиллахыг хүсье.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН



430021043



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2020.07.22 № 01/1388
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ц.ЭРДЭНЭСҮРЭН ТАНАА

Хуулийн хэрэгжилтийг зохион
байгуулж ажиллах тухай

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-аар мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай төрийн албаны эрх зүйн үндсийг бататган тогтоож, төрийн жинхэнэ албан хаагч улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг мөрдлөг болгон ажиллахыг хуульчилсан билээ.

Төрийн албаны шинэтгэл нь хуулиа дээдэлсэн, иргэндээ үйлчилдэг, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд суурилсан, улс төрөөс ангид, шударга, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх явдал юм.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т "улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх" гэж, 37 дугаар зүйлийн 37.1.4-т "улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх нийтлэг үүрэг хүлээнэ" гэж, 39 дүгээр зүйлийн 39.1.5-д "төрийн жинхэнэ албан хаагч улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцохыг хориглоно", 39.1.6-д "... аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглахыг хориглоно" гэж тус тус заасныг төрийн байгууллага, төрийн жинхэнэ албан хаагч сахин биелүүлэх үүрэгтэй.

Төрийн жинхэнэ албан хаагч орон нутгийн сонгуульд нэр дэвших тохиолдолд хууль дээдлэх зарчмыг баримтлан зайлшгүй дагаж мөрдөх зарим хуулийн лавлагааг хүргүүлж байна.

1.Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4-т "Төрийн жинхэнэ албан хаагч ... аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн жилийн 08 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө ... төрийн албанаас чөлөөлөгдсөн байна." гэж заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагч 2020 оны орон нутгийн ээлжит сонгуульд нэр дэвших бол төрийн албанаас чөлөөлөгдөнө. Энэ нь тухайн иргэн төрийн албанаас өөрийн сонголт, санаачилгаар чөлөөлөгдөж байгаа үйлдэл юм.

20002830

2.Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.1-т "... аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвших болсон үндэслэлээр төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албанаас чөлөөлнө" гэж заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэнийг төрийн албан хаагчийн нөөцөд байгаад тооцохгүй бөгөөд төрийн жинхэнэ албанд эргэж орох тохиолдолд төрийн албаны ерөнхий болон тусгай /тухайн албан тушаалын/ шалгалт өгөн хамгийн өндөр оноо авч зохих журмын дагуу нэр дэвшүүлсний үндсэн дээр уг албан тушаалд томилогдох эрх шинээр үүсэх болно.

3.Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.1-т заасан үндэслэлээр төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх шийдвэрийг 46.5-д заасны дагуу хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн шууд захирагч 46.4-т заасан хугацаанаас өмнө гаргасан байна. Уг шийдвэрт төрийн албанаас чөлөөлөгдсөнөөс үүсэх эрх зүйн үр дагаврын талаар зөвлөсөн заалтыг тусгаж өгөх нь зүйтэй юм.

4.Төрийн албан хаагч сонгуульд нэр дэвшихэд Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдөх боломжгүйг урьдчилан анхааруулах, зохих нотолгоо баримтыг бүрдүүлэн үндэслэл сайтай шийдвэр гаргах нь зүйтэй.

5.Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д "Энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй" гэж заасан. Тодруулбал, төрийн жинхэнэ албан хаагчид хориглох зүйлийг зөрчсөн албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөөд зогсохгүй төрийн албан тушаалд томилогдохгүй байх шалтгаан болох юм.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүн, Засгийн газраас байгуулсан төсөл, хөтөлбөрийн нэгж болон хамтын удирдлагын байгууллагын орон тооны болон орон тооны бус гишүүн нарыг уг хуульд заасан хугацаанаас өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байхаар хуульчлан зохицуулсан байна.

Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалыг Засгийн газрын 2019 оны 25, 276 дугаар тогтоолоор тогтоосныг судална уу.

Төрийн албан хаагч сонгуульд нэр дэвшихтэй холбоотой тухайлсан харилцааг Төрийн албаны тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, журамд заасныг үндэслэн шийдвэрлэж байхыг зөвлөө.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ